



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххайрхан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/104/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны захирал  
аудитор Ч. Мөнхцооз

Утас: 99028555

цахим хаяг: munhuu8555@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	2
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	4
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	9
3.8 Аудитын гол асуудал .....	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт.....	10
4.1 Залруулсан алдаа.....	10
4.3 Төлбөрийн акт.....	11
4.4 Зөвлөмж .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	12

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

МӨНХХАЙРХАН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ У.ДОЛГОРСҮРЭН ТАНАА

2022.02.24 № 2/01  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнххайрхан сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөнххайрхан сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДВААТАР

311020412

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>44,238,118</b>	<b>40,726,543</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>44,238,118</b>	<b>40,726,543</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,205,300</b>	<b>319,300</b>
35130	Эм боох материал	1,205,300	319,300
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>43,032,818</b>	<b>40,407,243</b>
35410	Бичиг хэргийн материал	307,300	290,000
35420	Аж ахуйн материал	2,278,052	2,300,002
35440	Түлш, шатах тослох материал	4,721,120	539,920
35450	Барилгын засварын материал	1,914,500	204,000
35460	Хүнсний материал	4,992,920	7,372,795
35470	Бусад хангамжийн материал	28,818,926	29,700,526
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>385,740,192</b>	<b>369,348,899</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>385,740,192</b>	<b>369,348,899</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>377,617,442</b>	<b>361,340,399</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	346,604,440	346,604,440
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,967,713)	(36,589,757)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,511,140	41,108,140
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,810,675)	(25,818,579)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,148,629	30,945,985
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,790,580)	(14,164,719)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,556,625	21,159,875
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,741,000)	(6,011,562)
39217	Ном	4,106,576	4,106,576
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>8,122,750</b>	<b>8,008,500</b>
39301	Програм хангамж	557,000	557,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(214,250)	(328,500)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,780,000	7,780,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>429,978,310</b>	<b>410,075,442</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>51,757</b>	<b>1,968,161</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>51,757</b>	<b>1,968,161</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>51,757</b>	<b>1,968,161</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	51,757	1,968,161
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>429,926,553</b>	<b>408,107,281</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>429,926,553</b>	<b>408,107,281</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	117,259,834	117,259,834
51101	Өмч: - төрийн	117,259,834	117,259,834
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>194,977,716</b>	<b>173,158,444</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	194,977,716	194,977,716
51220	Тайлант үеийн үр дүн		(21,819,272)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,689,003	117,689,003
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>429,978,310</b>	<b>410,075,442</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>431,324,682</b>	<b>270,264,622</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>311,491,362</b>	<b>250,385,700</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>59,829,862</b>	<b>555,100</b>

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,829,862	555,100
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,829,862	555,100
120009	Бусад орлого	-	
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>251,661,500</b>	<b>249,830,600</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	251,661,500	249,830,600
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>119,833,320</b>	<b>19,878,922</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>107,100,520</b>	<b>9,464,322</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	460,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,100,520	9,004,322
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>12,732,800</b>	<b>10,414,600</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,732,800	10,414,600
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>280,387,262</b>	<b>292,083,894</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>280,387,262</b>	<b>292,083,894</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>260,710,462</b>	<b>272,856,471</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>192,308,869</b>	<b>187,142,742</b>
210101	Үндсэн цалин	133,552,774	126,571,513
210102	Нэмэгдэл	43,866,895	48,297,388
210104	Урамшуулал	14,889,200	12,273,841
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,078,863</b>	<b>24,456,345</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,593,151	16,279,424
210202	Тэтгэмжийн даатгал	1,952,644	1,871,427
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,562,115	2,248,798
210204	Ажилгүйдлийн даатгал	359,423	365,042
210205	Эрүүл мэндийн даатгал	3,611,530	3,691,653
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,156,452</b>	<b>14,445,800</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,499,382	1,964,600
210302	Түлш, халаалт	8,257,070	12,081,200
210303	Цэвэр, бохир ус	400,000	400,000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,755,932</b>	<b>2,610,980</b>
210401	Бичиг хэрэг	538,800	247,300
210402	Тээвэр, шатахуун	759,100	646,960
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000	57,100
210404	Ном, хэвлэл	15,000	60,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	423,770
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,092,132	586,500
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,075,900	589,350
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,646,725</b>	<b>13,088,475</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	223,700	1,481,800
210502	Хоол, хүнс	12,159,725	11,206,175
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	263,300	400,500
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>249,400</b>	<b>2,880,500</b>
210604	Урсгал засвар	249,400	2,880,500
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>71,900</b>
210702	Дотоод албан томиллолт	-	71,900
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>312,000</b>	<b>467,600</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,000	143,600
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	324,000

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,202,220</b>	<b>27,692,129</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,000,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	179,000	2,795,624
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,023,220	22,896,505
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,676,800</b>	<b>19,227,423</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>8,580,552</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,580,552
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>19,676,800</b>	<b>10,646,871</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,676,800	10,646,871
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>150,937,420</b>	<b>(21,819,272)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>461,516</b>	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	461,516	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(461,516)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>150,475,904</b>	<b>(21,819,272)</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834	117,689,003	194,977,716		429,926,553
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,259,834	117,689,003	194,977,716	-	429,926,553
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834	117,689,003	194,977,716	-	429,926,553
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834	117,689,003	194,977,716	-	429,926,553
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,259,834	117,689,003	194,977,716	-	429,926,553
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(21,819,272)		(21,819,272)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834	117,689,003	173,158,444	-	408,107,281

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>264,313,400</b>	<b>244,733,520</b>	<b>249,598,329</b>	<b>249,598,329</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>264,313,400</b>	<b>244,733,520</b>	<b>249,598,329</b>	<b>249,598,329</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>264,313,400</b>	<b>244,733,520</b>	<b>249,598,329</b>	<b>249,598,329</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>196,305,600</b>	<b>193,008,928</b>	<b>187,142,741</b>	<b>187,142,741</b>
210101	Үндсэн цалин	130,427,100	125,037,933	118,712,641	116,935,844
210102	Нэмэгдэл	52,039,500	51,931,743	55,709,500	55,709,500

210104	Урамшуулал	13,839,000	16,039,252	12,720,600	14,497,397
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,501,200</b>	<b>23,455,292</b>	<b>24,456,345</b>	<b>24,456,345</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,649,000	16,158,221	16,776,445	17,105,236
210202	Тэтгэмжийн даатгал	1,963,100	1,824,240	1,920,000	1,764,866
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,570,400	1,459,552	1,535,800	1,703,312
210204	Ажилгүйдлийн даатгал	392,500	364,500	384,000	350,509
210205	Эрүүл мэндийн даатгал	3,926,200	3,648,779	3,840,100	3,532,422
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,264,600</b>	<b>10,264,600</b>	<b>9,064,600</b>	<b>9,064,600</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,964,600	2,499,382	1,964,600	1,964,600
210302	Түлш, халаалт	7,900,000	7,365,218	6,700,000	6,700,000
210303	Цэвэр, бохир ус	400,000	400,000	400,000	400,000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,969,200</b>	<b>3,969,200</b>	<b>861,500</b>	<b>861,500</b>
210401	Бичиг хэрэг	78,100	78,100	69,400	69,400
210402	Тээвэр, шатахуун	640,000	640,000	568,900	568,900
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64,200	64,200	57,100	57,100
210404	Ном, хэвлэл	44,600	44,600	39,600	39,600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,142,300	3,142,300	126,500	126,500
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,387,600</b>	<b>9,592,300</b>	<b>12,971,843</b>	<b>12,971,843</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,198,900	2,198,900	391,900	391,900
210502	Хоол, хүнс	19,412,500	6,617,200	12,183,743	12,183,743
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	776,200	776,200	396,200	396,200
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,468,200</b>	<b>2,377,200</b>	<b>1,350,000</b>	<b>1,350,000</b>
210604	Урсгал засвар	2,468,200	2,377,200	1,350,000	1,350,000
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>71,900</b>	<b>71,900</b>
210702	Дотоод албан томилолт	-	-	71,900	71,900
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>343,600</b>	<b>343,600</b>	<b>467,600</b>	<b>467,600</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600	143,600	143,600	143,600
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	200,000	324,000	324,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,073,400</b>	<b>1,722,400</b>	<b>13,211,800</b>	<b>13,211,800</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	2,000,000	2,000,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,073,400	1,722,400	11,211,800	11,211,800

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>264,394,300</b>	<b>244,717,500</b>	<b>260,245,200</b>	<b>249,598,329</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>251,661,500</b>	<b>231,984,700</b>	<b>249,830,600</b>	<b>239,183,729</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	251,661,500	231,984,700	249,830,600	239,183,729
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>12,732,800</b>	<b>12,732,800</b>	<b>10,414,600</b>	<b>10,414,600</b>
132001	Орон нутгийн төсвөөс	12,732,800	12,732,800	10,414,600	10,414,600
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>19.00</b>	<b>19.00</b>	<b>19.00</b>	<b>19.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00	3.00	3.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>18.00</b>	<b>18.00</b>	<b>18.00</b>	<b>18.00</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	10.00	10.00	10.00	10.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00	5.00	5.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00	3.00	3.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан / төгрөгөөр**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>107,100,520.00</b>	<b>9,464,322.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,000,000.00</b>	<b>9,464,322.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,000,000.00</b>	<b>883,770.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>883,770.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	423,770.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	460,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>8,580,552.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>8,580,552.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,580,552.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>104,100,520.00</b>	<b>-</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	104,100,520.00	-
221001	Их засвар	104,100,520.00	-
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>107,100,520.00</b>	<b>9,464,322.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>107,100,520.00</b>	<b>9,464,322.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	460,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,100,520.00	9,004,322.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнххайрхан сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа, хоол хүнсний материалын худалдан авалт болон төсвийн хэмнэлтийг хангаж ажиллахтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны аудитор Ч. Мөнхцооз 2022 оны 2 дугаар сарын 11-нээс 2021 оны 2 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ний өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алсын хараа-2050, Нэгдсэн үндэсний байгууллагын ерөнхий Ассамблейгаас баталсан “Тогтвортой хөгжил 2030”, Монгол улсын их хурлаас баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” /2014-2024/, боловсролын тухай хууль болон холбогдох бусад хууль, үндэсний хөтөлбөрүүд, Сургуулийн өмнөх боловсролын талаар гаргасан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх байгууллагын зорилгоо тодорхойлж төлөвлөлт, дүрэм журам боловсруулж түүнийгээ мөрдлөг болгон ажилласан байна.

Байгууллагын 2017-2021 оны “Хөгжлийн хөтөлбөр”-т нийт 8 зорилтын хүрээнд 63 төрлийн ажил төлөвлөсөн ба хамт олны хурлаар хэлэлцүүлж биелэлтийг тооцсон. Үүнээс: 36 ажил 100 хувьтай биелж, 27 ажил 30-70 хувийн биелэлттэй 2021 оны байдлаар биелэлт 94.1 хувьтай хэрэгжсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

*Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2017 оноос хойш шинэчлэлт хийгдээгүй.

2021 онд аймгийн Засаг даргын тамгын газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн. Харин Засаг даргын дэргэдэх дотоод аудитын албанаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгдээгүй, Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 оны санхүүгийн тайланд аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнххайрхан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны батлагдсан төсвийн 260245.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 5204.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4163.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнххайрхан сумын цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19902.9 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлага данс үлдэгдэлгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 40726,5 мянган төгрөг болж 3511,6 мянган төгрөгөөр буюу 7,9 хувиар буурсан байна. Энэ нь түлшний үлдэгдэл 4181,2, засварын материал 1710,5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 16391,3 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 8400,0 мянган төгрөгийн 3 ширхэг компьютер шууд худалдан авалт хийсэн, хүүхдийн хоолны сав суулга гэрлэн хаяг гэх мэтийн тавилга эд хогшлыг 1090,0 мянган төгрөгөөр бэлтгэж орлогод авсан. Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 28-ны 39 тоот тогтоолоор ашиглагдах боломжгүй болсон тавилга эд хогшлыг данснаас хассан зэрэг өөрчлөлт хөдлөлүүд нөлөөжээ.

Мөн дээрх үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдлийн зардал 22896,5 мянган төгрөг байснаас цэвэр хөрөнгийн дүн буурчээ.

Тайлант оны 7,8 дугаар сард олгосон амралтын мөнгийг нийгмийн даатгалын тайланд дутуу тусгаснаар нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, ХХОАТ-н өглөг бүртгэгдээгүй байсныг аудитын явцад өглөг бүртгэн залруулсан.

Засгийн газрын оролцоо дансны дүн 21819.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 21819.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Мөст сумын цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 260245.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 260245.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 260245,2 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 260245.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 249830.6 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 10414.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс / тогтмол зардлыг санхүүжүүлэх/ санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 249830.6 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 10414.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс / тогтмол зардлыг санхүүжүүлэх/ бүрдүүлж 10646.8 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 249598,3 мянган төгрөг болж 95.9 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшуул, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6321.1, мянган төгрөгөөр, хоолны зардал 4325.7 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт дансаар сумын иргэдээс цар тахлын халдвараас сэргийлэх ажлын хүрээнд иргэдээс өгсөн ариутгал, халдвар хамгааллын материалын үнэнд 460,0 мянган төгрөг хандивласан, БСГ-аас Ковид-19 цар тахлын хүрээнд олгосон ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 423,7 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 8580,5 мянган төгрөг, нийт 9464,2 мянган төгрөгийн орлого орж тус тусын зориулалтын дагуу зарцуулагджээ.

Нэмэлт санхүүжилтийн тайланг 2,6-д хавсаргав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд топилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа 145 мэдээллийг хугацаандаа оруулж, мэдээлэл хугацаа хожимдож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Аудитын явцад хийсэн хяналтаар төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангуудыг мэдээлсэн байдлыг үзэхэд 6 тайлангаас 6 хугацаандаа мэдээлсэн, цалингаас бусад 5,0 сая төгрөгийн үнийн дүнтэй ажил гүйлгээ 1 ширхэг 8400,0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлсэн байна.

#### Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6,1-д “Энэ хуулийн 3,1,13,1,2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, хүүхдийн хоолны зардал нормоос илүү зарцуулагдсан, тооллого үнэн зөв хийгээгүй, НДШ-н тайлан 362,6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зэрэг зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын дүнгээр шилэн дансны мэдээллийн бүртгэл сайжирсан, хоолны норм хэтрээгүй, хөрөнгийн материалын эдийн засгийн ангиллыг залруулсан байна. Харин НДШ-н тайланд цалингийн дүн зөрүүтэй тусгаснаар НДШ-н өглөг бүртгэгдээгүй тооцоонд ороогүй байсныг аудитын явцад тогтоон залрууллаа. Эдгээр нөхцөл байдлаас дүгнэлт хийхэд өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна. Зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг тооцон 2021.06.14-ны өдрийн 14 тоот албан бичгээр аудитын газарт хүргүүлжээ.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

дараагийн аудитаар анхаарах асуудал тусгаагүй байна.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18223,3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2561.7 мянган төгрөгийн алдааг залруулж, ХХОАТ суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүй 283,9 мянган төгрөгийн акт тогтоож, батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаагүйтэй холбоотой 15377,7 мянган төгрөгийн үнийн дүн бүхий зөвлөмж, хүүхдийн хоол хүнсэнд шаардлагатай мах нийлүүлэх, хүнсний материал худалдан авах тендер зарлаагүй, гэрээ байгуулаагүй анхан шатны баримт бүрэн бүрдүүлээгүй зэрэг алдааг засах нийт 2 төрлийн зөвлөмж өглөө.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1.НДШ-н өглөг бүртгээгүй 1684,1 мянган төгрөгийн алдаа илэрсэн

2. ХХОАТ-н өглөг бүртгээгүй 283.9 мянган төгрөгийн алдаа
3. Үндсэн хөрөнгийн ангилал зөрүүлсэн 520.0 мянган төгрөгийн алдаа
4. Боловсрол соёлын газраас Жайка төслөөр нийлүүлсэн 73.6 мянган төгрөгийн материал орлого бүртгээгүй

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад дээрх алдааны 2561.7 мянган төгрөгийн залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг аудитын явцад залруулсан.

#### **4.2 Төлбөрийн акт**

Илрүүлэлт. ХХОАТ-т 8 дугаар сард ажиллагсаас суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүй 283,9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх акт тогтоолоо.

Шийдвэрлэсэн нь. Төлбөрийн акт тогтоов.

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **4.3.1 Худалдан авалттай холбоотой асуудал**

4.3.1. *Илрүүлэлт:* Хүүхдийн хоол хүнсэнд шаардлагатай мах нийлүүлэх, хүнсний материал худалдан авах тендер зарлаагүй, гэрээ байгуулаагүй компани болон хувь хүнээс мах болон хүнсний материалаа худалдан авсан НӨАТ-н баримт зарим иргэн аж ахуйн нэгжээс аваагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

4.3.2. *Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн

байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 6.4.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох" гэж заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

#### **4.3.2 Төсвийн хэмнэлттэй холбоотой асуудал**

4.3.3 *Илрүүлэлт:* "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах, цахилгаан дулааны эрчим хүч цэвэр усны хэрэглээний 20-оос доошгүй хувийн хэмнэлт гаргах,

4.3.4. *Өгсөн зөвлөмж:* "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс / сая төгрөгөөр/							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнххайрхан сумын цэцэрлэг	6	18223.3	4	2561.7	1	283.9	0	0	1	15377.7

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Х.БОЛДБААТАР**

АУДИТЫН МЕНЕЖЕР: **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

АУДИТОР: **Ч.МӨНХЦООЗ**

